



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны 3 сарын 11 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Гэрчилгээний загвар батлах тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 10 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Сонгуулийн хороонд ажиллах ажилтны сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох журам”-ын 3.1.1 дэх заалт, Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын сургалт явуулах, гэрчилгээ олгох журам”-ын 1.2 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.“Сонгуулийн хороонд ажиллах ажилтны сургалт зохион байгуулах эрхийн гэрчилгээ”-ний загварыг 1 дүгээр хавсралтаар, “Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын сургалт зохион байгуулах эрхийн гэрчилгээ”-ний загварыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

00000061

Сонгуулийн ерөнхий хорооны
2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн
31 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

СОНГУУЛИЙН ХОРООНД АЖИЛЛАХ АЖИЛТНЫ
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ
ЗАГВАР



СОНГУУЛИЙН ХОРООНД АЖИЛЛАХ АЖИЛТНЫ
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЭРХИЙН
ГЭРЧИЛГЭЭ

Дугаар.....

..... НЬ
“Сонгуулийн хороонд ажиллах ажилтны сургалтын хөтөлбөр”-ийн дагуу
боловсруулагдсан дараах сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулах эрх
олгов.

1. Сонгуулийн хууль тогтоомж, сонгуулийн байгууллага, түүний зохион байгуулалт
2. Сонгуулийн нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, сонгогчдын нэрийн жагсаалт
3. Сонгуулийн мөрийн хөтөлбөр, сурталчилгаа, сонгуулийн зардал
4. Сонгогчийн санал авах ажиллагаа
5. Сонгуулийн дүн, мэдээ, тайлан гаргах
6. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, гомдол маргаан хянан шийдвэрлэх харъяалал

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН
ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА

/...../

/Тамга/

..... оны дугаар сарын-ны өдөр

Энэхүү гэрчилгээ нь төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үр
дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх шалгуур үзүүлэлт болно.

Сонгуулийн ерөнхий хорооны
2021 оны 3 дугаар сарын 18-ний өдрийн
31 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН БАГИЙН ГИШҮҮН, ДААМЛЫН
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ
ЗАГВАР



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН БАГИЙН ГИШҮҮН, ДААМЛЫН
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЭРХИЙН

ГЭРЧИЛГЭЭ

Дугаар.....

..... нь
“Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын сургалтын
хөтөлбөр”-ийн дагуу боловсруулагдсан дараах сэдвийн хүрээнд сургалт
зохион байгуулах эрх олгов.

1. Сонгуулийн автоматжуулсан систем, эрх зүйн орчин
2. Санал тоолох төхөөрөмжийн үйл ажиллагаа, санал хураалтад бэлтгэх болон гарч болзошгүй гэмтэл, саатал, шийдвэрлэх арга зам
3. Санал тоолох төхөөрөмж ашиглан хийх дадлагын хичээл
4. Санал авах байранд хяналтын камер байрлуулах, ашиглах
5. Сонгуулийн автоматжуулсан системийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй танилцуулах

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН
ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА

/...../

/Тамга/

..... оны дугаар сарын-ны өдөр

Энэхүү гэрчилгээ нь төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үр
дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх шалгуур үзүүлэлт болно.